


СТОУС-ын өөрчлөлтүүд болон бусад чухал сэдвүүд



PwC экспертүүдтэй хамт СТОУС-ын өөрчлөлтүүдтэй танилцаарай!

2022 оны 10 сарын 13

Санхүүгийн тайлангийн олон улсын стандартууд нь дэлхий даяар хамгийн өргөн хэрэглэгддэг нягтлан бодох бүртгэлийн стандарт бөгөөд байнга шинэчлэгдэж байдаг. Энэхүү сургалт нь СТОУС-ын хамгийн сүүлийн үеийн шинэчлэлт, чиг хандлагын талаар мэдээлэл өгөх болно.

2021 оны нэгэн адил 2022 онд олон улсын санхүүгийн тайлангийн стандартад өмнөх жилүүдтэй харьцуулахад төдийлөн их өөрчлөлт ороогүй ч бага зэргийн өөрчлөлтүүд орсон. Нягтлан бодох бүртгэлийн стандартад нэвтэрсэн өөрчлөлтүүд нь санхүүгийн тайлан бэлтгэгчдэд тустай байж болохуйц хэд хэдэн тодруулга эсвэл практик хялбаршуулалтуудыг багтаасан. Энэхүү сургалт нь СТОУС-ын хамгийн сүүлийн үеийн хөгжил дэвшил, чиг хандлагын талаархи мэдээллийг өгөх бөгөөд Санхүүгийн тайлагналын олон улсын тайлбарын хорооны хэлэлцэх асуудлын шийдвэрүүдийг практик жишээ, асуултуудаар дамжуулан тайлбарлана.

Нэмэлт өөрчлөлтүүдээс гадна түрээстэй холбоотой чухал сэдвүүд, групп болон нэгдсэн хяналт бүхийн этгээдүүдийн бизнесийн нэгдлийг хэрхэн зохицуулах, зээлийн өөрчлөлтийг хэрхэн шийдвэрлэх, худалдах, буцаан түрээслэх гүйлгээ зэрэг бусад чухал сэдвүүдийг хэлэлцэх болно

Энэ сургалт нь хэнд зориулагдсан бэ?

Энэхүү сургалт нь СТОУС-ын хамгийн сүүлийн үеийн өөрчлөлттэй танилцаж, тэдгээрийн бизнест үзүүлэх нөлөөлөлд бэлтгэх хүсэлтэй санхүүгийн захирал, санхүүгийн шинжээч, нягтлан бодогч, санхүүгийн хянагч/менежер, аудитын мэргэжилтнүүд болон дотоод аудиторуудад зориулагдсан.

Сургалтын багш:



Габор Балазс
PwC Унгар || Партнер || СТОУС нягтлан бодох бүртгэлийн зөвлөгөө

Габор нь Төв болон Зүүн Европын PwC-ийн Академи болон Нягтлан бодох бүртгэлийн зөвлөх үйлчилгээний бүсийн удирдагч юм. Тэрээр 20 гаруй жилийн турш нягтлан бодох бүртгэлийн нарийн төвөгтэй асуудлаар бүс нутгийн томоохон үйлчлүүлэгчдэд дэмжлэг үзүүлж ирсэн туршлагатай.

Габор Төв болон Зүүн Европ, Азийн 27 орныг хамарсан СТОУС-р мэргэшсэн партнер юм. Тэрээр PwC СТОУС-ын Нягтлан бодох бүртгэлийн гарын авлагын хамтран зохиогч бөгөөд СТОУС-ын сургалтыг олон улсын PwC оффисуудад удирдан зохион байгуулдаг.

Габорын сургалтанд оролцогчид сургалтаар СТОУС-ын талаар үргэлж шинэ зүйлийг сурч, түүний туршлагын ачаар нягтлан бодох бүртгэлийн аливаа сэдвээр сонирхолтой практик жишээг хуваалцах боломжтой болдог гэсэн байна.

Сургалтын агуулга:

- СТОУС 16 - Түрээс (чухал сэдвүүд)
- SaaS, Нийлүүлэгчийн санхүүжилтийн зохицуулалт
- Групп болон нэгдсэн хяналт бүхийн этгээдүүдийн бизнесийн нэгдэл
- Цахим шилжүүлгээр хүлээн авсан бэлэн мөнгө
- Худалдах, буцаан түрээслэх
- Үнэ цэнийн бууралтын шинэчлэл (IAS36)
- Мөнгөн гүйлгээ (IAS7)
- Шинэ стандартын нэмэлт өөрчлөлтүүд, СТОУТХ-ын хэлэлцэх асуудлын шийдвэр, НББОУБ-ын ажлын төлөвлөгөө

Дэлгэрэнгүй мэдээлэл:

Хэзээ: 2022 оны 10 сарын 13

Бүртгэл: 09:00

Сургалт: 09:15 – 17:00

Хаана: Улаанбаатар Зочид буудал, 2 давхарт сургалтын өрөө

Хэл: Англи хэл дээр монгол орчуулгатай

Төлбөр: 800,000 ₮ + НӨАТ

Та бидэнтэй anujin.amar@pwc.com,
enkhtsetseg.tsogtgerel@pwc.com хаягаар холбогдоно уу